



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 26 өдөр

Дугаар А/373

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.1.5 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.6 дахь заалт, Засаг даргын удирдлагын зөвлөлийн 2025 оны 16 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орхон аймагт 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 05-ны өдрүүдэд зохион байгуулагдах Монголын хүүхдийн зөвлөлийн "Майхант цугларалт"-д аймгаа төлөөлж оролцох хүүхдүүдийн оролцооны зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

2. Шаардагдах 1,800,000 (нэг сая найман зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Эрдэнэбат)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

